



**НИЙСЛЭЛИЙН БИЕЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ**

2014 оны 10 сарын 20 өдөр

Дугаар А/59

Улаанбаатар хот

Нийслэлийн Иргэдийн спортын  
III наадмын Сагсан бөмбөгийн  
тэмцээн зохион байгуулах тухай

Монгол Улсын "Биеийн тамир, спортын тухай" хуулийн 10 дугаар зүйл, Засгийн газрын 2009 оны 05, 2014 оны 43 дугаар тогтоолууд, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн мөрийн хөтөлбөр, эдийн засаг, нийгмийн 2014 оны зорилтыг хэрэгжүүлэх, Нийслэлийн Засаг даргын 2013 оны А/333 дугаар захирамжийг үндэслэн ТУШААХ нь:

1. Нийслэлийн Иргэдийн спортын III наадмын Олс таталтын тэмцээнийг 2014 оны 11 дүгээр сарын 01-02-ны өдрүүдэд "Буянт-Ухаа" спортын ордонд зохион байгуулсугай.
2. Тэмцээнийг зохион байгуулахад шаардагдах төсвийг нэгдүгээр, шүүгчдийн бүрэлдэхүүнийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.
3. Тэмцээнийг зохион байгуулахад шаардагдах 1.908.000 /нэг сая есөн зуун найман мянга/ төгрөгийг Нийслэлийн Биеийн тамир, спортын газрын орон нутгийн төсвийн иргэдийн спортын наадмын зардлаас гаргахыг нягтлан бодох О.Эрдэнэцэцэгт зөвшөөрсүгэй.
4. Тэмцээнийг урьдчилсан бэлтгэлийг сайтар хангаж зохион байгуулалтын өндөр хэмжээнд явуулахыг мэргэжилтэн Б.Түвшинбаярт үүрэг болгосугай.

ДАРГА



Ж.ГАНБОЛД

1150500135